



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/642

Хэрлэн сум

«Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах  
үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, салбар дундын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд уялдуулан зохицуулах, хуулийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсугай.

Орлогч дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга  
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга  
Эрүүл мэндийн газрын дарга  
Нийгмийн даатгалын хэлтсийн дарга  
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга  
Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны Тэргүүн  
Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрчний эвлэлийн салбар зөвлөлийн дарга

2.

Монголын Хараагүй иргэдийн холбооны Хэнтий аймгийн салбар зөвлөлийн дарга

Аймгийн Тэргэнцэртэй иргэдийн холбооны тэргүүн

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны тэргүүн

Нарийн бичгийн дарга:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудал болон тэдний орчин нөхцөлийг сайжруулах талаар үр дүнтэй ажиллахыг орон тооны бус салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зохион байгуулсан ажлын тайлан мэдээг заасан хугацаанд аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлд тайлагнаж ажиллахыг салбар зөвлөлийн орлогч дарга /Д.Өнөрцэцэг/-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/421 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ